

2022 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 01/22

Улаанбаатар хот

2021 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ^{22/02} тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2022 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 02/22

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулан батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ^{24/02} тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг нэмэлт, өөрчлөлт оруулан нэгдүгээр Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан дүрмийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэн хянуулж, Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2022 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 03/22

Улаанбаатар хот

Давуу эрхийн хувьцаа
гаргахыг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 болон 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ~~22/01~~ тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн эздийн өмчийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт татах зорилгоор хавсралтад заасан нөхцөлөөр давуу эрхийн хувьцаа гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж давуу эрхийн хувьцаа гаргах хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2022 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 04/22

Улаанбаатар хот

Хоёрдогч өглөг
гаргахыг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11 дахь хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ^{22/05} тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн эздийн өмчийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт татах зорилгоор хавсралтад заасан нөхцөлөөр хоёрдогч өглөг гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж хоёрдогч өглөг гаргах хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ